

МОНГОЛ СОЛОНГОС ХЭЛ, БИЧГИЙН ХАРИЛЦАА ХОЛБООГ СУДЛАХ АРГАЗҮЙН АСУУДАЛД*

Ц.Шагдарсүрэн

Олон улсын Улаанбаатарын их сургууль
Профессор, Доктор (Sc.D)

Аливаа гадаад хэлийг судлана гэдэг нь тухайн хэлийг сайн мэддэг мэргэжилтэнтэй байхаас эхлэдэг. Монгол хэлийг гадаад дахинд судалсан байдлыг авч үзвэл, 995 онд Солонгосын арван оюутан монгол газар ирсэн тухай профессор Б.Сумьяабаатарын баримт¹ нь одоо бидний мэдэх хэрээр хамгийн эртнийхи нь болж байна. Түүх соёлын харилцаа бүхий улс орнуудын хэл, бичгийг судлах ажлын хүрээнд Монгол хэл, бичгийг судлах ажил Солонгосын Чосөн гүрэн (조선 제국 [朝鮮帝國], 1392-1910)-ий үед улам эрчимжсэн² нь нэгэн талаас үндэсний бичиг үсгээ буй болгох их зорилготой нь холбоотой байсан гэж үзэх баримт үндэс бий.

Энэ далимаар нэгэн зүйлийг онцлон хэлэхэд монгол хэл бичгийг судлах ажил Европ дахинд үүнээс нэлээд хойно эхэлсэн бөгөөд одоо буй баримтаар Францад Melchisédech Thévenot (1620-1692/1693)-ийн “Монгол хэлний зүйн найруулал” хэмээх сурах бичиг 1672 онд³, Jean-Pierre Abel Rémusat (1788 -1832)-гийн Төв Азийн олон ард түмний хэл болон бичгийн судалгааны бие даасан томоохон бүтээл 1820 онд⁴ тус тус гарчээ. Jean-Pierre Abel Rémusat-гийн хэдэн зуун хуудас бүхий бүтээлд Төв Азийн хятад, төвөд, манж, зүрчидээс гадна солонгос хэл, бичгийн тухай хэсэг байдаг нь солонгос нөхдийн анхаарлыг татна гэж бодож байна.

Монголчуудын тухайд монгол солонгос хэл, бичгийн харилцаа холбооны талаархи анхны мэдээллийг эрдэм шинжилгээний хүрээнд 1959 онд Улаанбаатар хотноо болсон Олон Улсын Монгол Хэл бичгийн эрдэмтэний анхдугаар Их хурал дээр Хон Гимүн (홍기문) профессорын “Солонгос, монгол хэлний харьцаа” гэдэг товч боловч өргөн хүрээтэй илтгэлээс анх авсан⁵

* 2016 оны 7-р сарын 20-21-нд Улаанбаатар хотноо болсон МУИС, Солонгосын Sun Moon Их сургуулиас хамтран хийлгэсэн *Beyond the cultural border of the East Asia* сэдэвт ЭШ-ний хуралд тавьж хэлэлцүүлсэн илтгэл. Солонгос орчуулгаар *Journal of Dong-Ak Language and Literature* сэтгүүлд хэвлэгдэн гарна.

¹ Б.Сумьяабаатар, *Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд*. Улаанбаатар, 1978, [228 тал], 12-р тал.

² Song Ki-joong, *The Study of Foreign Languages in the Choson Dynasty (1392-1910)*, Korean Studies Dissertation series № 1, Seoul, 2001, [213 pp.].

³ Melchisédech Thévenot, *L'essai de la grammaire mongole*, Paris, 1672.

⁴ Abel Rémusat, *Recherches sur les langues Tartares on mémoires*, Paris, 1820; [Энэ номын 1-р ботийг 2013 онд Hachette Livre хэвлэлийн газраас [464 хуудастай] хэвлэн гаргажээ.]

⁵ Хон Ги Мүн, *Солонгос, монгол хэлний харьцаа*, - Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний

бөгөөд илтгэгч нутагтаа буцсаны дараа уг илтгэлээ солонгосоор хэвлүүлсэн байна⁶. Одоо Монголд солонгосын судлал хэдийнээ өргөн хүрээнд буй болжээ. Монголд хэлбичиг (Philology), түүх зэрэг салбараар солонгосын судлалын эх суурийг анх тавьсан хүнийг профессор Б.Сумьяабаатар гэж хэлэхэд маргах хүн гарахгүй гэж итгэж байна.

I. Монгол, солонгос хэлний харилцаа холбоог судлах асуудал

I. 1. Монгол, солонгос хэлний нийтлэгийн судалгаа

Цаг хугацаа, орон зайн хамаарлаас үл шалтгаалах зүйл үгүй тул монгол солонгос хэлийг Алтай овогт багтана (Typologically common features / Identical origin) хэмээж харьцуулан судлах нь нэгэн загвараар хийх ажил огт биш. Монгол, солонгос хоёр хэлийг харьцуулан судлахад зөвхөн уг хоёр хэлээр хязгаарлалгүй түрэг, манж-хамниган, япон зэрэг Алтай язгуурын хэл болон тэдгээр хэлний нутаг нутгийн аялгууны баримтыг ч харгалзаж үзэхгүй байхын аргагүйг хэлэх хэрэгтэй. Бас аливаа хэлний нийтлэг (Universal)-ийн асуудал ч хамаарна. Түрүүн гарсан эрдэмтэдийн нухацтай томоохон судалгаанаас үзвэл⁷ давын өмнө дараахи хоёр онцлог харагдана. Үүнээс өмнө эл илтгэлийн зохиогч хоёр хэлний харьцуулсан судалгааны аргазүйд хамаарах нэг бус өгүүлэл нийтлүүлж байсан болно⁸.

анхдугаар Их хурал, 2-р дэвтэр, Эмхэтгэсэн Ж. Цолоо, - *Studia Mongolica*, Tomus II, Fasciculi 17-23, Ulan-Bator, 1961, 313-324-р тал.

⁶ “조선어문” сэтгүүл, 1959 он, № 6, 77-82-р тал.

⁷ [Оны дарааллаар:] Е. Д. Поливанов, *К вопросу о родственных отношениях корейского и “Алтайских” языков*, [стр. 156-164] - Статьи по общему языкознанию, Москва, 1968, [376 стр]; Charles Haguenaue, *Novelles recherches comparées sur le Japonais et les Langues Altaïque*, [Collège de France, Bib. De l’Institut des Hautes Etudes japonaises], Paris, 1975; Б. Сумьяабаатар, *XIII-XIV зууны монгол солонгос харилцааны бичгүүд*, (Тэргүүн дэвтэр), Улаанбаатар, 1978, [252 тал]; К. Н. Menges, *Korean and Altaic - A Preliminary Sketch*, - *CAJ*, Vol. 28, Wiesbaden, 1984, pp. 234-295; С. А. Старостин, *Алтайская проблема и происхождение японского языка*, Москва, 1991, [298 стр.]; Gerhard Doerfer, *Altaica gottingensia*, - *CAJ*, 45 / 2, Wiesbaden, 2001, ss. 181-229; Martine Irma Robbeets, *Is Japanese Related to Korean, Tungusic, Mongolic, and Turkic?* - *Turcologica* 64, Wiesbaden, Harrassowitz Verlag, 2005, [pp. 975].

⁸ Ts. Shagdarsürting, *Problems of Methodology of Altaic Comparative Linguistics*, - *Rocznik Orientalistyczny*, Tom. LVIII, Zeszyt 1 (Opera Altaistica professori Stanislawo Kafuzynski octogenario dicata), Warszawa, 2005, pp. 179-187; Ц. Шагдарсүрэн, *Солонгос хэлний баримт монгол хэлний түүхийн судлагдахуун болох нь* - Халимаг болон Монголын ойродуудын хэл аялгуу, соёлын түүхэн хэлхээ холбооны асуудалд, Улаанбаатар, 2009, 87-92-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний олон аялгуунаа үеийн хэлбэр салаалан хөгжсөн нь* (Монгол болон Алтай овогийн бусад хэлний баримт), - Халимаг болон Монголын ойродуудын хэл аялгуу, соёлын түүхэн хэлхээ холбооны асуудалд, Улаанбаатар, 2009, 73-86-р тал; (체. 샬다르수링) 비교연구 방법으로 몽골어와 한국어의 역사적 관계를 연구하는 것에 대하여 [권성훈(몽골 국립대) 번역] / *On the Methodology of Historical-Comparative Studies of Mongolian and Korean Languages - Current Trends in Altaic Linguistics: A Festschrift for Professor Emeritus Seong Baeg-in on His 80th Birthday*, Kim Juwon and Ko Dongho eds., Seoul: Altaic Society of Korea, 2013, pp. 477-484.

I. 1. 1. Судалгааны олон баримтыг авч үзвэл нэг хэсэг нь одоогийн байдлаараа, гадаад хэлбэр болон утгазүйн хувьд ойр, төстэй, бүр адил байх нь ч буй. Үүнд давын өмнө хэлбэр сулал (Morphology) буюу үгзүйд холбогдох язгуур бүтээврийн нийтлэгийн асуудлыг хамааруулж болно. Жишээ нь (энэ удаад холбогдох бүх баримтыг нэг дор толилуулах бололцоогүй, бас хэлний үзэгдлийн ганц нэг баримт санамсаргүй буюу тохиолдолын байж болох тул хэл-тогтолцоо (System) гэдгийн үүдээс тус тус хоёроос доошгүй жишээгээр толоолүүлэн товч танилцуулах болно):

Алтай овог хэлнээ ‘хаа-, хавчи-, хаши- ...’ гэдэг утга бүхний $\sqrt{qa-}$ / $\sqrt{ka-}$ хэмээх язгуур нийтлэг буй. Монгол хэлнээ энэ язгуураас үүссэн үйл үгийн олон хэлбэрээс гадна *хаалга, хаалт, хавирга, хавис, хавхаг, хайс, хайч, халбага, хашиа, хашига, хашилга ...* гэх зэрэг олон нэр үг дам дам үүсчээ. Хоёр үгээр жишээ татахад:

Мо. *qabirγ-a* (< Мо. **qalbirγ-a*) ‘хавирга’; Oirat: *хавис*;

Кор. 갈비 | *kalpi* ‘хавирга’;

Manchu. *χalbi* ‘хавирга’;

Мо. *qayici*; Кор. 가위 | *kawi* ‘хайч’; Turk. (Yakut) *qawiti*;

Manchu. *χasaχa* ‘хайч’ (*χasalambi* ‘хайчлаж байна’)⁹;

Cf. Мо. *qabci-* ‘хавчи-’.

Энэхүү язгуураас үүссэн ‘савх’ гэсэн утгатай үг япон хэлнээ *hashi* хэмээх хэлбэртэй, бас ойрад монголчууд ‘халбага’-аа одоо ч *хашиу*¹⁰ гэдэг билээ. Үүнээс үзвэл овог Алтай хэлний уг $\sqrt{qa-}$ / $\sqrt{ka-}$ язгуур монгол, солонгос, түрэг, манж, япон хэлнээ идэвхитэй байсаар байна. Энэ мэт олон язгуурыг жагсааж болно.

I. 1. 2. Ногоо хэсэг нь мэргэжлийн бус хүний нүдэнд огт хамааралгүй мэт харагдавч хэлний түүхэн хөгжил (Historical development)-ний явц, хэл хэлний салбарлаж зэргэцэн хөгжих ((Parallel individual development)-) жам ёсыг түүхэн авназүй (Historical phonetics), үгзүй (Morphology), утгазүй (Semantics) зэрэг хэлшинжлэлийн олон төвшинд задлан үзэх бөгөөс хамаа холбоотой гэж үзэхээс оор аргагүй, гол төлөв түүхэн авназүй (Historical phonetics)-д хамаарах нэгэн хэсэг баримт буй.

⁹ Иван Захаров, Полный Маньчжурско-Русский словарь, Санктпетербургъ, 1975, [I-XXX + 2-64 + 1-6 + 1-1129 стр.], стр. 384-385; William Rozycki, Mongol Elements in Manchu, Indiana University, Bloomington, 1994 [255 pp.], p. 103.

¹⁰ Гарлыг нь авч үзвэл, монгол хэлнээ бичи- > бичиг, сүрчи- > сүрчиг, тоно- > тоног, хоно- > хоног болдог үйлээ нэр үг үүсдэг жишээгээр хаши- > хашиг болсон нь тодорхой харагдана. Энэ далимаар тэмдэглэхэд, одоогийн ‘хашаа’ (< *qasiγ-a*) гэдэг үгийг монгол бичигийн хэлнээ *qasiγ-a* хэмээн бичсэн баримт бас буй тул түүнтэй андуурч үл болно.

Хэлний хөгжлийн энэ мэт үзэгдлийг хэл хэлэнд байдаг нийтлэг (Universal)-ийн үүднээс ерөнхий хэлшинжлэл (General linguistics)-ээс салгаж үзэхийн аргагүй. Энэ нь бичгийн дурсгал дээр үсэгзүй ([Paleo]graphics)-д холбогдоно. Товчоор хэлэхэд тухай тухайн хэлний өнгөрсөн хөгжлийн зам чийрийг хэлшинжлэлийн үүднээс сэргээж одоогийн хэлбэр яаж гарсаныг тэнхрүүлнэ гэсэн үг. Гурван үгээр жишээ гаргая:

- PM. *nindun 'нүд' > Mo. nidun > Khal. нүд;
 (!) Kor. 눈 nun;
 (!) Evenk. nundun;
- PM. *möndüri 'мөндөр' > Mo. möndür > Khal. мөндөр;
 (!) Kor. (нутагийн аялгуу) 무리 muri¹¹ 'мөндөр'.
- PM. *qalbirγ-a 'хавирга' > Mo. qabirγ-a 'хавирга';
 (!) Kor. 갈비 kalpi 'хавирга';
 (!) Manchu. xalbi 'хавирга'.

Дээрхи гурван жишээг хэл хэлний бие дааж зэргэцэн салбарлаж хөгжсөний дүнд, олон хэлнээ байдаг Cluster хэмээх үзэгдлийн үр дүн гэж тайлбарлаж болно. Өөрөөр хэлбэл энэ тохиолдолд үгийн дунд хоёр үеийн зааг дээр дараалан орсон -nd-, -lb- (зэрэг) гийгүүлэгч хоюулаа хадгалагдсан, эсвэл аль нэг нь гээгдсэнтэй холбоотойгоор тухай тухайн үгийн одоогийн хэлбэр уг хэлэндээ хэрэглэгдэж байна гэсэн үг. Үүнээс гадна -ng- зэрэг өөр бүтэц сугардаг баримт Алтай хэлний бусад хэлэнд ч ажиглагддаг¹².

Үүнчлэн хэлний бие даасан хөгжилд хэл хэлэнд нийтлэг байдаг Haplology гэдэг үзэгдэл үгийн сангийн хүрээнд шинэ үг үүсгэх хүчин зүйл болдог ч тэр зарчимыг мэдэхгүй тохиолдолд, жишээ нь: монгол бичгээр хармагц ялгадаг байсан бол орчин цагийн монгол хэлнээ шинэ үсгийн зохиомол дүрмийн харгайгаар тийнхүү үүссэн шинэ хэлбэрийг тухайн үгийн хэлзүйн өөр хэлбэртэй андууран буруу ойлгох, буруу бичих явдал гарсаар байна. Хэлшинжлэл бол мэргэжлийн шинжлэх ухаан, ярьдаг болгон тэр хэлээ сайн мэддэг судлалтан биш тул хоосон цэцэрхэж мэдэмхийрэх хэрэггүй гэдгийг анхаарах цаг хэднйнээ болсон.

¹¹ А. А. Холодович, Корейско-русский словарь, Москва, 1958, [896 стр], стр. 326.б. [Тэмдэглэх нь: Энэхүү niigi 'мөндөр' гэдэг үг солонгос, монгол хэлнээ гарал нэгтэй гэдгийг Хон Ги-мүн профессор анх 1959 онд тэмдэглэсэн (5-р хэсэг, 320-р тал) бөгөөд энэхүү өгүүллийн зохиогч уг үг солонгос хэлний нутгийн аялгуунд байдагийг хайж тодруулах, чухам хэрхэн холбогдож болох судалгааг хийж дээр дурдсан Cluster-ийн үүднээс бусад хэдэн үгийн хамт тогтолцоотой үзэгдэл гэдгийг нутлахыг оролдож энэ санаагаа үүнээс өмнө хэд хэдэн өгүүлэлд дэвшүүлсэн болно.]

¹² Жишээ нь: монгол хэлний тэнгэр, монгол гэдэг үгийг Түва хэлнээ дээр, моол гэж байгаа нь хоёр үеийн зааг дээр дараалан орсон -ng- гийгүүлэгч сугарсаны үр дүн болно.

1. 2. Монгол, солонгос хэлний хөгжлийн түүхэн үе шатын онцлогийг хадгалсан баримтыг судлах нь

Зөвхөн монгол, солонгос гэлтгүй Алтай овогийн бусад хэлний хүрээнд баримтыг харьцуулан судлахад хэл хэл өөр өөрийнхөө жамаар бие даан зэргэцэн хөгжихдөө гаднаас нь харахад хамаагүй мэт санагдаж болох ч яргуулан хөөж үзвэл олон зүйл тодорч, цөм цаанаа нарийн учир холбогдолтой болох нь харагдана.

Францын нэрт монголч эрдэмтэн Поль Пеллио (Paul Pelliot 1878-1945) орчин цагийн монгол хэлнээ эгшигээр эхлэсэн олон үг Дундад үеийн монгол хэлнээ *h*-ээр эхлэсэн байдагийг судлаад Алтай овог хэлний **p-* > **ʃ / *φ* > **h* > *∅* [**p-* > **f* > **h* > *∅*] хэмээх авиазүйн тогтолцоо байсаныг батласан билээ¹³. Энэхүү тогтолцооны гол гол баримтыг солонгос, манж хэлнээс хэлнээс бид олж харж болно. Үүнд:

Mo. aday~alay ‘адаг~алаг’;	MM. halaqan	Kor. pa-dag	파닥;	Ma. falangyu;
Mo. ilay-a ‘ялаа’;	MM.	Kor. p’a-ri	파리;	Ma.;
Mo. ulayan ‘улаан’;	MM. hula’an	Kor. pulg-in	푼은;	Ma. fulgiyan;
Mo. üliye- ‘үлээ-’;	MM.	Kor. pul-da-	푼다;	Ma. fulgiyere-.

Энэхүү жишээ нь П.Пеллиогийн тодорхойлсон тогтолцоогоор солонгос хэл нь хамжих *p-*, манж хэл нь *f*, дундад үеийн монгол хэл нь шүргэх *h*-тай, орчин цагийн монгол хэлнээ үгийн эхний тэрхүү хамжих гийгүүлэгч нэгэнт *∅*-болсоныг харуулах баримт хэмээн үзэж болно.

1. 3. Солонгос хэлний баримт монгол хэлний судлалд хамаарах нь

1. 3. 1. Солонгос хэлний түүхэн хөгжлийн баримт нь монгол хэлний хөгжлийн олон үе шатыг авиазүй, хэлбэр судлал, утгазүйн салбарт тодруулах чухаг баримт болж өгдөгийг хэлвэл зохино¹⁴. Үүнд холбогдох солонгос хэлний баримтын нэлээд зүйл дээр жишээ татсан хэсэгт буй тул дахин давтан нурших хэрэггүй гэж үзлээ.

1. 3. 2. Солонгосын ханз хэлний баримт

Солонгосын ханз хэлний баримт монгол солонгос хэлний харилцаа холбооны чухаг судлагдахуун болж чадна. Энэ нь цаашилбал эртний монгол хэлний

¹³ Pelliot P, Les mots a H - initiale aujourd'hui amuie dans le mongol des XIIIe et XIVe siècles, - Journal Asiatique, April-June, 1925, [pp. 193-263], p. 197.

¹⁴ Ц. Шагдарсүрэн, Солонгос хэлний баримт монгол хэлний түүхийн судлагдахуун болох нь - Халимаг болон Монголын ойродуудын хэл аялгуу, соёлын түүхэн хэлхээ холбооны асуудалд, Улаанбаатар, 2009, 87-92-р тал; Ц. Шагдарсүрэн, Монгол хэлний олон аялгуунаа үгийн хэлбэр салаалан хөгжисөн нь (Монгол болон Алтай овогийн бусад хэлний баримт), - Халимаг болон Монголын ойродуудын хэл аялгуу, соёлын түүхэн хэлхээ холбооны асуудалд, Улаанбаатар, 2009, 73-86-р тал.

баримтыг хятад ханз үсгээр галиглаж ирсэн дурсгалын судалгаатай шууд холбогдоно. Өөрөөр хэлбэл харь үгийг хятад ханз үсгээр тэмдэглэдэг тусгай тогтсон уламжлалын үүднээс ханзаар галигласан тэрхүү баримтыг солонгос дуудлагаар сэргээхэд (Франц зэрэг Европын эрдэмтэдийн нээн тогтоосон¹⁵) өртөөлсөн олон шаг дамжилгагүй, шууд унших боломжийг олгож судалгааг үлэмж дөхөмтэй болгоно гэсэн үг. Үүнд: Солонгост гарсан “*Мянган үсгийн соёл*” (千字文)¹⁶ хэмээх, хятад ханзын солонгос дуудлагыг солонгос үсгээр галиглан хадсан бүтээлийн хэд хэдэн хувилбар хэвлэл онцгой ач холбогдолтой хэмээн үзэж байна. Энэ далимаар хэлэхэд эл чухаг бүтээлийн нэгэн эхийг Улаанбаатар хотноо 2011 онд профессор Чой Ги-хо (최기호), Б. Сумьяабаатар нар гэрэл зургаар хэвлүүлж холбогдох монгол тайлбар сэлтийг хавсаргасан билээ¹⁷.

Солонгосын ханз хэлний дуудлага нь зөвхөн монгол, солонгос хэлний харилцааны асуудалд төдийгүй, Алтай овог хэлтэнээс хятад бичиг хэрэглэж ирсэн бусад ард түмэнтэй, мөн солонгосоор Японыг нэрлэдэгтэй давхар холбогдох учир буй¹⁸. Жишээ нь:

¹⁵ (Зохногчийн нэрийн дараалалаар:) Baxter William H., An Etymological Dictionary of Common Chinese Characters, Preliminary Draft of 28 October 2000 [Sec: Alexander Vovin, Once Again on the Tabgač Language, - Mongolian Studies, Journal of The Mongolia Society, Volume XXIX, 2007, Indiana, Bloomington, [pp. 191-206], see pp. 194, 201: note 1.]; Boodberg Peter A., Some proleptical remarks on the Evolution of Archaic Chinese, - HJAS Vol. 2, Cambridge 1937, pp. 329-372; Chavannes Ed., Inscriptions et pièces de Chancellerie chinoises de l'époque mongole, - T'oung pao, - Serie II, Vol. VI, Leide, 1904, pp. 357- 447 / - T'oung pao, - Serie II, Vol. VI, Leide, 1905, pp. 1-42. / T'oung pao, - Serie II, Vol. IX, Leide, 1908, pp. 297-428; Karlgren B., The reconstruction of Ancient Chinese, - T'oung pao, - Serie II, Vol. XXI, Leide, 1922, pp. 1-42; Karlgren B., Grammata serica recensa, Stockholm, 1964, 332 pp.; Ligeti L., Le Tabghach, un dialecte de la langue Sien-pi, - Mongolian Studies, edited by L.Ligeti, Budapest, 1970, p. 292.; Maspero Henri, Etudes sur la phonétique historique de la langue Annamite, - Bulletin de l'Ecole Francaises d'Extrême-Orient (BEFEO), 1912; Maspero Henri, Le dialecte de Tch'ang-ngan sous les T'ang, Bulletin de l'Ecole Francaises d'Extrême-Orient (BEFEO), 1920; Mullie P. Jos, Une caractéristique phonologique du dialecte chinois de la Mongolie centrale, - T'oung pao, - Vol. XXIII, Leide, 1924, p. 67 – 82; Pelliot P., Sur quelques travaux chinois manuscrits concernant l'époque mongole, - T'oung pao, - Vol. XXVIII, Leide, 1932, p. 378-380; Schaank S. H., Ancient Chinese Phonetics, Part I and II - T'oung pao, - Serie I, VIII Vol., Leide, pp. 361-377, 457-486; Schlegel G., The Secret of the Chinese method of transcribing foreign sounds, - T'oung-Pao, Serie II, Vol. I, E. J. Brill, Leide, 1900, pp. 1-32, 93-124, 217-253; Vovin Alexander, Once Again on the Tabgač Language, - Mongolian Studies, Journal of The Mongolia Society, Volume XXIX, 2007, Indiana, Bloomington, pp. 191-206.

¹⁶ 崔世和 著, 漢字 教本 三書 研究 附 影印本, 大學社, 서울, 1993, (124 pp. + 影印本: 丙子本 千字文 (1 p. + 一前 - 三十二 後), 松廣寺本 千字文 . 類合 [(1 p. + 一前 - 三十二 後), (一前 - 三十二 後)], 固城本 訓蒙字會 [(9 p. + 上 一前 - 三十五 後), (中 一前 - 三十五 後), (下 一前 - 三十五 後 + 1 p.)]).

¹⁷ Чой Ги-хо (최기호), Б. Сумьяабаатар, Монгол-Солонгос-Нангиад “Мянган үсгийн соёл”-ын харьцуулсан судалгаа, Ulaanbaatar University Press, Улаанбаатар, 2011, [А-4: 268 тал].

¹⁸ Ц. Шагдарсүрэн, Ханзаар галиглан тэмдэглэсэн эртний монгол үгийг солонгос ханзын дуудалгаар сэргээх боломж, - Монгол-Солонгос хэл соёлын харилцааны хөгжлийн чиг хандлага (몽골과 한국의 언어와 문화 관계의 발전 경향), Эмхэтгэсэн С. Батхишиг, Улаанбаатар, 2013 [151 тал], 25-60-р тал: (солонгос орчуулга: 25-34, монгол эх хавсралт

日 (Chin. 日 / цоон тохиолдолд хүний нэрнээ 日), гол илэрхийлэх утга нь 'нар(ан)'. Энэ ханзын солонгос дуудлагыг солонгос “*Мянган үсгийн соёл*” (千字文) номд уг хятад дуудлагаас огт өөр буюу 日 [nal (~ nar)], 일 (il) хэмээн уг номын бүх хувилбарт эргэлзээгүй нэгэн адил хадан өгчээ. Үүнийг 日 [nal (~ nar)] гэдэг хэлбэр нь монгол хэлний 'нар' (<Mo. naran), 일 (il) гэдэг нь солонгосчууд японыг нэрлэдэг 日本 (Il ron) гэдэг нэртэй тус тус холбогдоно.



Солонгос “*Мянган үсгийн соёл*” (丙子本 千字文, 一前) номд 日 хэмээх ханзын дуудлагыг солонгосоор тэмдэглэсэн байдал

Энэ бол ганцхан ханзын жишээ. Энэ мэт бидний анхаарлыг татах олон ханз буй бөгөөд дээр эшлэлд заасан өгүүлэлдээ үүнийг бичигч 乞 (Chin. qǐ / qì; Kor. 걸 kel; Mo. kele ‘хэл’¹⁹), 水 (Chin. shuǐ; Kor. 물 [mul] / 물 [mül ‘yc’]; Mo. mösün < * mölsün ‘mөc’) гэдэг өөр хоёр ханзыг тус тус авч үзсэн бөлгөө. Энэ далимаар тэмдэглэхэд орчин цагийн монгол хэлний ‘mөc’ хэмээх үг нь “*Хуа-йн ии-йү*” (華夷譯語) толь бичиг болон Инжаннашийн үеийн монгол шүлэгт ‘mөлсүн’ гэдэг хэлбэртэй, одоо ч буриадын аялгуунаа тэр хэлбэрийг хадгалан ‘mөлхүн’ гэдэг. Хэлний энэхүү үзэгдэл нь бидний дээр (I. 1. 2-т) тайлбарлан өгүүлсэнчлэн, үгийн дунд хоёр үеийн зааг дээр дараалан орсон -ls- гийгүүлэгчийн хэвээр хадгалагдсан буюу аль нэг нь сугардаг Cluster-ийн асуудал. Монгол хэлний mөлсүн (> буриад: mөлхүн) хэмээх энэ хэлбэр нь солонгосын 물 mul ‘yc’ гэдэг үгийн хэлбэрт илүү ойрхон, утгазүйн орон (Semantic Field)-ы хувьд ч онц зөрчилдөх зүйл биш. Харин зарим эрдэмтэн солонгос хэлний 물 mul хэмээх үгийг ‘yc’ гэдэг утгаар нь монгол хэлний ‘морон’ гэдэг үгтэй холбон үзсэн нь буй²⁰.

зургийн хамт: 35-60) [Энэ өгүүлэлийн анхны хэвлэл 2010 гарсан болно: Ц. Шагдарсүрэн, Ханзаар галиглан тэмдэглэсэн эртний монгол үгийг солонгос ханзын дуудалгаар сэргээх боломж – Монголын солонгос судлал, I боть, эрхилсэн Б. Сумъяабаатар, Улаанбаатар, 2010, [214 тал], 125-131-р тал].

¹⁹ L. Ligeti, *Le Tabghach, un dialecte de la langue Sien-pi*, - Mongolian Studies, edited by L.Ligeti, Budapest, 1970, [pp. 265-308], p. 292.

²⁰ Е. Д. Поливанов, К вопросу о родственных отношениях корейского и “Алтайских” языков, [стр. 156-164] - Статьи по общему языкознанию, Москва, 1968, [376 стр], стр. 163.

I. 4. Ормол үг (Loan relation / Loan words)-нийн судалгаа

Нэг хэлнээс нөгөө хэлнээ үг орно гэдэг нь тухайн хоёр хэлний гарлын асуудалтай хамаагүй боловч тэдгээр улс орны нийгэм, улс-төр, эдийн засаг зэрэг түүхэн харилцаатай шууд холбоотой. Тэгээд ч олон эрдэмтэн солонгос хэлнээ орсон монгол үг хийгээд харилцан орсон үгсийн талаар нийгэм, хэлшинжлэлийн талаас нь судалсаар иржээ²¹.

II. Монгол, солонгос үсэг бичгийн харилцаа холбооны асуудал

Төв Азийн улс орны түүхийг үзвэл төр улсаа тулгар байгуулмагц өөрийн гэсэн бичиг үсэггүй буюу бусад улсын бичиг хэрэглэж байсан бөгөөс үндэсний бичигтэй болох эрмэлзэл нийтлэг байсныг Хятаны Ляо улс (遼 906-1125), Зүрчидийн Алтан улс (金 1115-1234), Тангадын Ся улс (夏 1032-1227), Манжийн Чин улс (清 Qing [1616-]1644-1911)-ын түүх бэлээхэнээ батлана. Харин монгол төрт Юан (元 1264/1271-1368) гүрэний үед Хубилай хааны зарлигаар 1269 онд зохиосон дөрвөлжин бичгийг Улсын бичиг болгосон нь монголчууд өөрийн бичиггүй байсантай холбоотой хэрэг огт бус Их Юан гүрэний харьяанд багтаж байсан хятад, төвөд, түрэг зэрэг олон хэлийн үндэстэнийг нэгэн бичгийн дор нэгтгэх бодлоготой холбоотой. Гэвч бусад улс үндэстэний аж төрөл, хэл соёл, бичиг, шашин сурталыг нь Юаны төрийн зүгээс хүлээн зөвшөөрөх *Pax Mongolica* ~ *Pax Mongolorum* хэмээх бодлогыг баримталсаар байсан гэдгийг мартахаар аргагүй²².

Дээрхи шалтгаанаар хятад дүрс бичгийг хэрэглэж ирсэн солонгосууд Жо-сөн улс (朝鮮 1392-1910)-аа байгуулаад дөтгөөр ван Сэжон (世宗 1397-1450) -гийн 25-р он буюу христусын тооллын 1443/1444 онд *Hunmin chōng'ŭm* (訓民正音)²³

²¹ (Оны дарааллаар:) Paul Pelliot, *Les mots mongols dans le Korye sa*, -*Journal Asiatique*, Tome CCXVII, Paris, 1930, pp. 253-266; Lee Ki-Moon, *Mongolian Loan-word in Middle Korean*, - *Ural-Altische Jahrbücher*, Tom. XXXV, Wiesbaden, 1964, pp. 188-197; Lee Ki-Moon, *Mongolian Loan-word in Korean*, - *Altai Hakpo*, No. 3, December 1991, Seoul, pp. 35-44; Karl A. Krippes, *Mongol and Jurchen words in a Middle Korean text*, - *Mongolian Studies (Journal of the Mongolia Society)*, Volume XV, 1992, Bloomington, pp. 97-109; Kim Ju-won, *Remarks on the Phonology of Mongolian Loanwords in Middle Korean*, -*Sinjilgen-ü ögülel, durasqal jokiyal*, Kökeqota, 1997, pp. 426-435; Квон Сон-Хүн, *Солонгос хэлэнд орсон зарим үгийн тухай ажиглалт*, - *Эрдэм шинжилгээний бичиг (МУИС, Монголын судлалын сургууль)*, Боть XVI (151), Улаанбаатар, 1999, 68-73-р тал; Квон Сон Хүн, *Монгол солонгос хэлэнд харилцан орсон зарим үгийн тухай*, - *Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг (МУИС, Монгол хэл, соёлын сургууль)*, Боть XIX (193), Улаанбаатар, 2002, 65-72-р тал; Kwon Seong Hun, *Жэжү аялгуунд орсон монгол үгийн авиазүйн онцлог*, - *Олон Улсын монголч эрдэмтэний XI их хуралд тавьсан илтгэл, товчлол: Илтгэлүүдийн товчлол, Улаанбаатар, 2016 [318 тал]: I салбар: Монгол хэл бичиг судлал, 43-р тал.*

²² Ts. Shagdarsurung, *Pax Mongolica or Pax Mongolorum - Mongolica Pragensia '15*, volume 8 No. 1, *Ethnolinguistics, Sociolinguistics, Religion and Culture*, Prague, 2015, pp. 9-21.

²³ Энэ нэрийг Б. Сумьяабаатар профессор 'монголоор Иргэнийг сургах илэрхий аялгуу | Иргэнийн сургах тов аялгуу' гэж, англиар профессор И Ги-мүн 'The Correct Sounds for the

хэмээх авианы, цагаан толгойг бичгээ зохион хэрэглэжээ. Солонгосын энэхүү шинэ бичиг нь алс хэтийг харсан, маш боловсронгуй, тэгээд ч өдгөөгийн цахим хэрэгсэлд шууд оруулах боломжтой гэдгийг хэлэх хэрэгтэй. Уг бичгийн онцлогийн талаар Жөн Ин-жи (정인지) гэдэг бичгийн түшмэл *Hunmin chōng 'ŭm* номд хавсаргасан оршилдоо:

...Эдгээр хорин найман үсгийг тоймгүй олноор хувилгаж болох нь хялбар болоод чухал, нарийн болоод өвөр зуураа зохицолдох тул сэргэлэн хүн нэгэн өдрийн дотор сэнхэрч, алмай муу нь арав хоногт сурч чадна... Мөн энэ үсгээр ... тэмдэглэхэд дутуу зүйл нэгээхэн ч үгүй, нэвтэрч үл хүрэх газар бас нэгээхэн ч үгүй... Салхин исгэрч, тогоруу дуугарч, тахиа донгодох, нохой хуцахыг ч энэ үсгээр бүгдийг тэмдэглэж болно...

хэмээн тодорхойлсон байдаг нь хоосон магтаал огт биш²⁴.

Солонгос *Hunmin chōng 'ŭm* бичгийг олон орны олон эрдэмтэн судласнаас үзвэл, аливаа бичигт гол суурь болдогчлон, авиазүйн онолын үндэслэл нь хятадын уламжлалт хэлзүйн баримтлалаас огт өөр гэдгийг бүгд хүлээн зөвшөөрчээ. Тэгвэл солонгос бичигт баримталсан тэрхүү үндэслэлийг тодруулан гаргахад уг бичгийг судлахын нэгэн гол ач холбогдол оршино хэмээн үзэж болно.

Энэ үүднээс солонгос бичгийг судлахад тухайн үеийн судалгааны гол байгуулга – Хятад, монгол, япон, зүрчид-манж дөрвөн хэлийг тусгайлан судлаж байсан Сайөгвөн (Sayōgwōn, 司譯院) хэмээх судалгааны байгуулгын үйл ажиллагааг анхаарахгүй байхын аргагүй. Профессор Хон Ги-мүн (1959), Song Ki-joong (송기중, 2001) нар бүтээлдээ Сайөгвөн (Sayōgwōn)-ий монгол хэлний салбарт монгол болон дөрвөлжин бичгийг судлаж байсан, монгол хэл, бичиг нь онолын зарчимаараа бусад гурвынхнасаа үлэмж ялгаатай гэдгийг онцлон тэмдэглэжээ²⁵. Солонгос бичгийг зохиоход баримталсан авиазүйн зарчим нь хятадын уламжлалаас огт өөр, тухайлбал: уг бичиг дүрс биш авианы бичиг учир цагаан толгойн үсгийн бүрэлдэхүүнийг эгшиг, гийгүүлэгч хэмээн тусгайлан хуваасан хийгээд үеийн бүтэцийг задлахдаа хятад үсэгт хэрэглэдэг эхин (The initial), адаг (The final) гэж үздэг хоёр байр (The Bi-partite)-т онолыг бус, эхин (The onset or Initial), дунд (The Peak or Medial), адаг (The Code or Final) хэмээх гурван байр (The Tri-partite)-т онолд үндэслэсэн зэрэг өвөрмөц

Instruction of the People', И Жүн-Хо 'Right Sounds to Educate the People', Song Ki-joong 'The Correct Sounds to Teach the People' гэж тус тус орчуулсан бол Л. Р. Концевич оросоор 'Наставление народу о правильном произношении' гэж орчуулсан байдаг.

²⁴ Утгыг тайлж хялбаршуулсан Хунмин жонг-ым, орчуулсан Д. Сайнбилэгт, Улаанбаатар, 2008, [А-4: 160 тал + эхүүдийн хавсралт], 96, 61-р тал.

²⁵ Хон Ги Мүн, Солонгос, монгол хэлний харьцаа, - Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар Их хурал, 2-р дэвтэр, Эмхэтгэсэн Ж. Цолоо, - Studia Mongolica, Tomus II, Fasciculi 17-23, Ulan-Bator, 1961, [313-324-р тал], 319-р тал; Song Ki-joong, The Study of Foreign Languages in the Choson Dynasty (1392-1910), Korean Studies Dissertation series № 1, Seoul, 2001, [213 pp.], 7-р тал.

онцлогтой болохыг судлагчид нээн тогтоожээ²⁶. Мөн уг бичгийг зохиохтой бараг зэрэг гарсан *Hunmin chōng'ŭm Haerye* (訓民正音解例, “*Explanation and Examples for the Hunmin chōng'ŭm*”) хэмээх тайлбар номд энэ мэт онцлогийг тохиолдол бүрээр нь тусгай хэсэг болгож бие даалган тайлбарласан байдаг²⁷. Хэрэвзээ авназүйн гурван байрт (The Tri-partite)-т энэ зарчмыг баримтлаагүй бол *Hunmin chōng'ŭm* бичиг авнаны цагаан толгойт бичиг болох боломж ерөөсөө байхгүй.

Сайогвон-д судлаж байсан дорвон зүйл хэл, бичгийг бодолцоход япон, зүрчид нар үеийн үсэг бүхний бичигтэй, манж нар тэр үед хараахан төр улсаа байгуулж амжаагүй тул манж хэмээх үндэсний бичгээ боловсруулаагүй нь тодорхой боловч монгол бичгийг хэвээр нь хэрэглэж байсан гэж үзэх магадлал буй. Ниймэд солонгос *Hunmin chōng'ŭm* бичгийн дээр өгүүлсэн авназүйн үндэслэл нь арга буюу монголчуудын хэрэглэж ирсэн авнаны цагаан толгойт монгол болон дөрвөлжин бичигт хамаарах учир шалтгааны боломж харагдана.

Hunmin chōng'ŭm бичгийн энэ мэт өвөрмөц онцлогийг зарчимын хувьд монголчуудын хэрэглэж ирсэн уламжлалт монгол бичиг, хятаны бага бичиг болон дөрвөлжин бичгийн тогтолцооноос олж харах боломжтой. Үүнд монгол, солонгос үсэг бичгийн холбоо харилцааны асуудлыг хоёр хэлийг харьцуулан судлахтай нэгэн адил гадаад буюу хэлбэрийн тал, дотоод тал буюу баримталсан онолын зарчим гэж хуваан үзэж болно²⁸.

Ингэж үзэж гэмээ нь солонгосын *Hunmin chōng'ŭm* бичгийн тогтолцооноос монголчуудын хэрэглэж ирсэн дээр дурдсан гурван бичигт байдаг ойр төстэй болон адил олон зүйлийг олж харж болно. Монголчуудын гурван зүйл бичгийн хүрээнд багцлан гол гэсэн ажиглагдахууныг товч толилуулбал:

Монгол бичгийн тухайл:

- Гадаад хэлбэрийн хувьд нэлээд олон үсгийн дүрс ойролцоо;
- Үгийн эхэнд эгшиг үсгийн гурван гол махбод (монгол бичигт: [5] буюу шүд / ацаг, [ʔ] буюу гэдэс, [V] буюу шилбэ; солонгос бичигт: [ㅇ] буюу тэнгэр, [ㅡ] буюу газар, [|] буюу хүн)-ыг соолжүүлэн байрлуулж тухай тухайн эгшиг үсгийг бүтээдэг зарчим;

²⁶ Lee Ki-moon, *Historical Studies on the Korean Writing System*, - Linguistics, Volume 18, The Korean research Center, Seoul, 1963 (Abstract in English), pp. 9-10.

²⁷ Jung Ho Yi, *Houlinmin Jung-um*, The Korean Alphabet "Right Sound to Educate the People", Explanation and Translation in Korean and English, Seoul, 1986, pp. 47-52.

²⁸ Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичгийн товчоон, Үсэгзүйн судлагаа, (Хүннүгийн үеэс өдгөө хүртэл Монголчуудын хэрэглэж ирсэн үсэг бичгийн судлагаа), - *Bibliotheca Mongolica*, Monograph: Tomus I, Centre for Mongol Studies (National University of Mongolia), Улаанбаатар, 2001, [А-4: 300 тал], 254-262-р тал; Ts. Shagdarsuren(g), A Study of the Relationship Between the Korean and the Mongolian Scripts, - *Mongolian Studies (Journal of the Mongolia Society [of USA])*, Volume XXV (2002), Bloomington, Indiana, pp. 59-84.

➤ Эгшиг үгийн дунд орохдоо монгол бичигт “титэм” (б), солонгос бичигт үгийн буюу үеийн дунд (ㅇ)- “i-üng” (ㅇ|ㅇ) орхигддог байдал:

	Эхин	Дунд	Адаг	Дуудалга
Монгол бичиг	ᠢ	ᠨ	ᠨ	ö ü
Дөрвөлжин бичиг	ᠢᠨ		ᠨ	ö
Солонгос бичиг	어		ㅏ	ö

➤ Гийгүүлэгч үсгийг өгүүлэх эрхтэний оролцоог харгалзан тайлбарлах зарчим...

Хятан бага бичгийн тухайд:

➤ Үгийг үе үеэр нь багцлаж бичдэг зарчим:

Хятан	Дөрвөлжин	Солонгос
1. 支	1. ᠢ	1. 아
	2. 2	2 3. 버
	3. 3	4 5. 지
1 2. 及		1. 우
		2. 2
1 2. 及	1. 1	3. 주
3. 及	2. 2	4. 4
	3. 3	1 2. 사
1 2. 及		3 4. 전
3 4. 及		5. 5

➤ Үеийг багцлаж бичихдээ тухайн махбодыг холбон бичих байр (Дээрхи хүснэгтээс хятан, солонгос бичгээр үе холбох байдлыг тодруулан үзнэ үү):

1 主	1 文	1 2 文伏	1 2 文半
	2 当		3 伏

Дорволжин бичгийн тухайл:

- Үгийг үе үеэр нь багцлаж бичдэг зарчим;
- Эгшиг үгийн дунд орохдоо дорволжин бичигт “их А”, солонгос бичигт “i-üng” орхигддог байдал;
- Гийгүүлэгч үсэг үгийн эхин, дунд, адагт орохдоо хэлбэр хувирдаггүй;
- Дорволжин бичигт “их А”, солонгос бичигт “i-üng”-ийг гийгүүлэгчийн бөлөгт багтаадаг ...

гэх зэрэг *Hunmin chōng 'yim* бичигт байдаг зарчимтай адил буюу төстэй зүйл олон бий. Тэгэхээр энэ мэт олон адил, төстэй зүйл байгаа нь санамсаргүй тохиодол гэж үзэх аргагүйн дээр цааш нь лавшруулан хөөж тодруулбал улбаагаараа эртний Энэтхэгийн алдарт Банни (Pāṇini)-й хэлзүйн уламжлалтай ч холбож болох сэжиг харагддаг.

Тэгээд ч профессор Ким Бонг-Тэ (김봉태) 2002 онд гаргасан томоохон бүтээлийнхээ дүгнэлтэд солонгос үсгийн үүслийг эртний Энэтхэгийн Деванагари (Deva-ḍāgarī, монголчууд *нагар үсэг* ч гэдэг), Монгол дорволжин бичиг, U-chaṅ (буюу төвөд²⁹) зэрэг үсэг бичигтэй холбож үзсэн байдаг нь санамсаргүй зүйл огт биш³⁰. Аливаа үсэг бичгийг боловсруулах, авах, солих явдал нь хуучин цагт шашин сурталтай, өдгөө цагт улс төр-үзэл сурталтай ямагт холбоотой байдаг тул Солонгосууд эртний Энэтхэгийн хэлшинжлэлийн онол сургаалыг харгалзсан нь Бүддийн шашин дэлгэрсэнтэй холбоогүй байхын аргагүй.

Бичгийн тогтолцооны хувьд дээр өгүүлсэнчлэн, монголчуудын хэрэглэж ирсэн хэдэн зүйл бичиг үсэгтэй адил төсний зүйл солонгос *Hunmin chōng 'yim* бичигт байгаагаас гадна монголчуудын үсэг бичгийн нөлөө солонгос бичигт туссан хэмээн үзэж буй бидний санал таамаглалыг дэмжих бас бус түүхэн мэдээ баримт ч олдсоор байна.

Тухайлбал: *Hunmin chōng 'yim* бичгийг хэрэглэж эхлэх үед Чой Ман-ли (崔萬理) зэрэг хүмүүс эрс эсэргүүцэж хятад бичгийг хэвээр байлгах гэж Их ванд оргосон айлтгалдаа “монгол, тангуд, зүрчид, япон, төвөд зэрэг бүдүүлэг зэрлэгүүдийн үсэг бичгийг даган хятад бичгийг сольж болохгүй”³¹ гээд

²⁹ Энэ нэр томъёо нь төвөд хэлний 'толгойг [үсэг]' буюу ᠳᠦᠰᠡᠭ dbu-ᠰaṅ гэдэг нэрээс гаралтай, ном зохиолд ангилар u-ᠰen, u-chen, u-ᠰaṅ гэх мэтээр тэмдэглэгдсэн байдаг ажээ.

³⁰ Kim Bong-Tae (김봉태), *Phonetic Relations between the Brahmi, U-chaṅ, hPags-pa, Devanagari, and Hangul Scripts*, Seoul, 2002 [245 pp.], see p. 245 (In Korean).

³¹ Уг айлтгалын англи орчуулга: "...Our Court, since the times of the Progenitor and Ancestors, has with utmost sincerity served the Great (shi-da). We have honored Chinese institutions solely. But now, at this time of identical culture and identical cartracks, we create the Vulgar Script. We observe and attend this with great alarm... If these graphs should flow into China, and if people there should adversely criticize them, how could we be without shame? ... Only types like the Mongolians, Tanguts, Jurchen, Japanese and Tibetans have their own graphs. But these are matters

бүдүүлгүүдийн жагсаалтыг монголоор эхлүүлсэн байдаг нь нэг талаас тухайн цагт монголчуудын үсэг бичгийн нөлөө харьцангуй илүү байсныг, нөгөө талаас бидний дээр өгүүлсэн монголчуудын үсэг бичиг солонгос *Hunmin chōng'ŭm* бичигт туссан гэдэг судалгааны баримтыг давхар давхар гэрчлэнэ.

Тэгвэл юуны учир хятад бичиг хэрэглэсээр ирсэн солонгосууд цаг хугацааны хувьд Юан улсын дараа шинэ зохиосон бичигтээ монголчуудын үсэг бичгийн тусгал нөлөөг авав гэдэг асуулт гарч болно. Үүнийг хэлний болон нийгмийн талаас авч үзэж болно.

Хэлний талаас авч үзвэл, солонгос хэл нь гарал (Origin) хийгээд хэвшинж (Typology)-ийн хувьд хятад хэлтэй адилгүйн учир хятад дүрс бичиг солонгос хэлэнд төдий л нийцтэй биш байсан гэдгийг *Hunmin chōng'ŭm* бичгийг эхлэж тайлбарлахдаа:

"...Манай улсын хэл аялгуу Хятадаас ялгаатай тул (хятад) бичгээр тэмдэглэхэд (тэрхүү ялгаа онцлог) зохих ёсоор гардаггүй. Тийм болохоор санасан бодсоноо бичин гаргаж үл чадах бүдүүлэг ард олон болой. (Иймд) ер нийт хүн сурч, өдөр тутам хэрэглэхэд амар дөхөмтэйг бодож хорин найман (үсгийн) тэмдэгтийг тулгар зохиов..."³²

хэмээн онцлож тэмдэглэсэн зүйл байдаг нь нэг талаас хятад болон солонгос хэл адилгүйн учир, нөгөө талаас солонгос түмнээ гэгээрүүлэх гэсэн зорилгоор уг бичгээ зохиосон болохыг батлаж байгаа хэрэг.

Зүрчид, манж нар ч солонгосуудын нэгэн адил Алтай хэлтэнд багтдагийн хувьд хэрэглэж ирсэн хятад дүрс бичгээ монгол туургатны үсэг бичгээс шууд буюу загвар авч авианы бичгээр сольсон нь эл шалтгаантай холбоотой буй заа. Нөгөө талаас тухайн цагтаа үлэмж нөлөө бүхий байсан Юан улсын дараа ч Монгол хэл, монгол бичгийн шаардлага хэрэглээ Төв Ази дахинаа өргөн байсан бөгөөд Мин (明, 1368-1644) улсын үед гарсан сургалтын зорилготой "*Монголын нууц товчоон*" (元朝秘史) болон *Хуа-йи йи-йү* (華夷譯語), *Монгол йи-йү* (蒙古譯語), *Бэй-лү йи-йү* (北虜譯語) зэрэг *йи-йү* (譯語 yi-уь ~ i-iu) маягийн олон толь бичиг, Солонгосын Жо-сөн улс (朝鮮 1392-1910)-ын дунд үед гарсан *Mong-ō nogöl-tae* (蒙語老乞大), *Ch'ōphae Mong-ō* (捷解蒙語) хэмээх сурах бичиг, *Mong-ō yuhai* (蒙語類解) гэдэг толь бичиг, Манж Чин улс (清 Qing [1616-]1644-1911)-ын үеийн монгол хэл, монгол бичгийн хэрэглээ болон Сөүл хотноо 1640 онд босгосон, (*Sam Jon-Do*-гийн гэж алдаршсан) манж, монгол, хятад гурван

of the barbarians ... To now separately make the Vulgar Script is to discard China and identify ourselves with the Barbarians... If you put the Vulgar Script into practice ... there certainly won't be very many people who know characters ... They will be futilely expert in the Vulgar Script ..." (English translation by J. R. Ledyard) See: J. R. King, The Korean Elements in the Manchu Script Reform of 1632, - "Central Asiatic Journal", Vol. 31, N. 3-4, Wiesbaden, 1987, pp. 252-286.

³² Jung Ho Yi, *Houlinmin Jirng-um*, The Korean Alphabet "Right Sound to Educate the People", Explanation and Translation in Korean and English, Seoul, 1986, p. 30.

хэлний хошоо зэрэг нь үүнийг гэрчилнэ³³.

Эцэст нь залуу судлагч нарт сануулан хэлэхэд, аливаа судалгааны ажилд, жишээ нь: монгол солонгос хэл хийгээд үсэг бичгийн холбоо харилцааны асуудлыг судлахдаа харьцангуй хялбар гэж хэлж болохуйц, гадаад хэлбэрээрээ ил тодорхой харагдах нийтлэгийн асуудлын хажуугаар хөгжлийн далд явцыг сэргээн тэнхрүүлэхэд, хэдийгээр товогтэй боловч, түлхүү анхаарч гэмээ нь өнөөдрийн хэмжүүрээр олон нууц “үл мэдэгдэхүүн”-ийг тодруулахад хүчин зүтгэсэн номын буянтай ажил болно.

³³ Ц. Шагдарсүрэн, Манж Чин Улс (清 Qing)-ын үе дэх монгол хэл, монгол бичгийн нийгмийн хэрэглээ, - International Conference: “Changing Patterns of Power in Historical and Modern Central and Inner Asia” (7-9 August 2014, Ulaanbaatar University, Ulaanbaatar, Mongolia) сэдэвт олон улсын ЭШ-ний хуралд тавьсан илтгэл, Abstract in English, pp. 55-56. Хэвлэгдсэн нь: Ц. Шагдарсүрэн, Манж Чин Улс (清 Qing)-ын үе дэх монгол хэл, монгол бичгийн нийгмийн хэрэглээ, - “Орчин үеийн Төв ба Өвөр Азийн орнуудын түүхэнд гарсан өөрчлөлт, хувьсал” [“Changing Patterns of Power in Historical and Modern Central and Inner Asia” (7-9 August 2014, Ulaanbaatar University, Ulaanbaatar, Mongolia) сэдэвт олон улсын ЭШ-ний хуралд тавьсан илтгэлийн эмхэтгэл, 230 тал], 196-204-р тал.